

**“Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт,
үйл ажиллагаа” техникийн туслалцааны төслийн хүрээнд
Дорноговь аймагт ажилласан тайлан**

2017-05-30

ХНХЯ-ны Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны дарга Т.Энхбаяр, холбогдох мэргэжилтэний хамт “Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” техникийн туслалцааны төслийн хүрээнд 2017 оны 5 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд хотод батлагдсан удирдамжийн дагуу ажиллаа. Энэ хүрээнд Дорноговь аймгийн ЗДТГ, техникийн туслалцааны төслийн жендэрийн зөвлөх багийн гишүүн, жендэрийн зөвлөх Т.Амгалан, Б.Онон нартай хамтран нийт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүллээ. Дээрх арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга Н.Хонгорзул болон аймгийн газар, хэлтсийн дарга, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл нийт 55 хүн хамрагдлаа.

1. Орон нутгийн удирдлага, жендэрийн салбар хорооны гишүүдэд жендэрийн үндсэн ойлголт, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, эрх зүй бодлогын орчин сэдвээр сургалт зохион байгуулж, 55 хүн хамрагдав.

2. Аймгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулж, батлуулах ажлын хэсгийн гишүүдэд орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулах үйл явц, үндэсний бодлогын уялдаа, дэд хөтөлбөр боловсруулах ажлын төлөвлөгөөний талаар сургалт зохион байгуулж, 13 хүн хамрагдав.

3. Барилга, хот байгуулалтын салбарын жендэрийн бодлогыг боловсруулах ажлын хүрээнд холбогдох удирдлагуудтай уулзалт, ярилцлага хийв.

Дорноговь аймагт ажилласан талаарх мэдээллийг ЖҮХ-ны фэйсбүүк хуудсанд байрлуулсан.

ХНХЯ-ны ЖҮХАА-ны дарга Т.Энхбаяр орон нутгийн телевизэд төслийн зорилго, хүлээгдэж буй үр дүнгийн талаар яриа, мэдээлэл хийсэн.

